



**МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ**

**2007 оны 6 дугаар  
сарын 27-ны өдөр**

**Дугаар 83**

**Улаанбаатар  
хот**

**Журам батлах тухай**

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2 дахь заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. “Монгол улсад бүртгэлтэй хуулийн этгээдээс гадаадын үнэт цаасны зах зээлд гаргах үнэт цаасыг бүртгэх журам”-ыг хавсралтаар баталж, 2007 оны 8 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.

2. Үнэт цаасны хороодын олон улсын байгууллагын гишүүн орнуудтай хоёр болон олон талт Харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурах ажлыг эрчимжүүлж, Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр Үнэт цаасны хороодын олон улсын байгууллагын Ази, Номхон далайн бүсийн хорооноос хэрэгжүүлж буй хөтөлбөрүүдэд Санхүүгийн зохицуулах хороог хамруулах талаар холбогдох байгууллагад асуудал тавьж шийдвэрлүүлэх арга хэмжээ авахыг Ажлын алба /О.Ганбат/-нд даалгасугай.

3. Журмыг нийтэд сурталчлан таниулах ажлыг зохион байгуулахыг Бодлого, зохицуулалтын газар /С.Ганболд/-т үүрэг болгосугай.

**ДАРГА**

**Д.БАЯРСАЙХАН**

## **МОНГОЛ УЛСАД БҮРТГЭЛТЭЙ ХУУЛИЙН ЭТГЭЭДЭЭС ГАДААДЫН ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛД ГАРГАХ ҮНЭТ ЦААСЫГ БҮРТГЭХ ЖУРАМ**

### **НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

1.1. Энэхүү журмаар Монгол улсад бүртгэлтэй хуулийн этгээд гадаад улсын үнэт цаасны зах зээлд үнэт цаасаа байршуулах, арилжих болон гадаадын үнэт цаас гаргагч компанийн үнэт цаас (цаашид “гадаад улсын үнэт цаас” гэх)-ыг Монгол улсад бүртгэлтэй хуулийн этгээдийн хөрөнгөөр баталгаажуулж гадаад улсын үнэт цаасны зах зээлд байршуулах, арилжих тохиолдолд Монгол улсад бүртгэлтэй тухайн хуулийн этгээдийн үнэт цаасыг Санхүүгийн зохицуулах хороо (цаашид Хороо гэх)-нд бүртгэх үйл ажиллагааг зохицуулна.

1.2. Гадаад улсын үнэт цаасны зах зээлд үүсмэл үнэт цаасаа гаргаж байршуулах, арилжих Монгол улсад бүртгэлтэй хуулийн этгээдэд Хорооноос зөвшөөрөл олгоход холбогдох бусад хууль, журмыг мөрдлөг болгоно.

1.3. Монгол улсад бүртгэлтэй хуулийн этгээдээс гадаадын үнэт цаасны зах зээлд гаргах үнэт цаасыг энэхүү журмын дагуу Хороонд бүртгэнэ.

1.4. Гадаад улсын үнэт цаасны зах зээлд гаргах үнэт цаасаа байршуулах, бүртгүүлэх тухай шийдвэрийг Монгол улсад бүртгэлтэй хуулийн этгээдийн эрх бүхий байгууллага гаргаснаас хойш 30 хоногийн дотор Хороонд бүртгүүлэхтэй холбогдох баримт бичгийг бүрдүүлэн ирүүлнэ.

### **ХОЁР. ХОРООНД БҮРТГЭХЭД ТАВИГДАХ ШААРДЛАГА**

2.1. Гадаад улсын үнэт цаасны зах зээлд үнэт цаасаа байршуулах, арилжих Монгол улсад бүртгэлтэй хуулийн этгээд нь дараах баримт бичгийг бүрдүүлнэ:

2.1.1. Гадаад улсын үнэт цаасны зах зээлд байршуулах, арилжих үнэт цаасаа бүртгүүлэхийг хүссэн өргөдөл (1 дүгээр хавсралтаар). /Өргөдөлд тухайн хуулийн этгээдийн ТУЗ-ын дарга гарын үсэг зурж, тамга дарж баталгаажуулсан байна/ Ирүүлсэн баримт бичгийн үнэн зөвийг гарын үсэг зурсан албан тушаалтан хариуцна.

2.1.2. Гадаад улсын үнэт цаасны зах зээлд үнэт цаасаа байршуулах, арилжих тухай хувь нийлүүлэгчдийн хурлын буюу төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэр;

2.1.3. Улсын бүртгэлийн гэрчилгээний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар;

2.1.4. Гадаад улсын үнэт цаасны зах зээлд байршуулах, арилжих үнэт цаасаа Хороонд бүртгүүлэх Монгол улсад бүртгэлтэй хуулийн этгээд нь Монгол улсын үнэт цаасны зах зээлд үнэт цаасаа давхар байршуулан нийтэд санал болгохоор шийдвэрлэсэн бол Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 7 дугаар зүйл болон Хорооны 2006 оны 36 дугаар тогтоолоор баталсан “Нийтэд санал болгон гаргах үнэт цаасыг бүртгэх тухай журам”-д заасан холбогдох баримт бичгийг бүрдүүлж ирүүлнэ.

2.1.5. Үнэт цаас гаргагч нь банкны үйл ажиллагаа эрхэлж буй хуулийн этгээд бол энэ талаарх Монголбанкны Ерөнхийлөгчөөс авсан албан ёсны зөвшөөрөл;

*/Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн 91 дүгээр тогтоолоор нэмсэн/*

2.1.6. Хорооноос шаардлагатай гэж үзсэн бусад;

*/Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн 91 дүгээр тогтоолоор нэмсэн/*

2.2. Монгол улсад бүртгэлтэй хуулийн этгээд нь гадаадын үнэт цаасны зах зээлд хувьцаа гаргах гэж байгаа бол энэ журмын 2.1-д зааснаас гадна дараах баримт бичгийг бүрдүүлэн Хороонд ирүүлнэ:

2.2.1. Хувьцаат компанийн хувьд Монголын үнэт цаасны зах зээлд байршуулан арилжаалж буй үнэт цаасны төрөл, тоо ширхэг, өргөдөл гаргахын өмнөх өдрийн үнэт цаасны арилжааны ханш, 52 долоо хоногийн дундаж ханш болон зах зээлийн үнэлгээний талаарх “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн тодорхойлолт;

2.2.2. Гадаад улсын үнэт цаасны зах зээлд байршуулах, арилжих гэж буй хувьцааны төрөл, нийт тоо ширхэг, байршуулах үнэ.

2.3. Монгол улсад бүртгэлтэй хуулийн этгээд нь гадаадын хууль тогтоомжийн дагуу гадаад улсын үнэт цаасны зах зээлд өрийн бичиг (бонд) гарган арилжих гэж байгаа бол энэ журмын 2.1-д дурдсанаас гадна дараах баримт бичгийг бүрдүүлж Хороонд ирүүлнэ.

2.3.1. Өрийн бичиг гаргагчийн танилцуулга;

2.3.2. Өрийн бичгийн талаарх танилцуулга (2 дугаар хавсралт).

### **ГУРАВ. БҮРТГЭХ, БҮРТГЭХЭЭС ТАТГАЛЗАХ**

3.1. Хороо нь гадаадын үнэт цаасны зах зээлд үнэт цаасаа байршуулах, арилжих гэж буй хуулийн этгээдийн үнэт цаасаа бүртгүүлэхээр хүсч ирүүлсэн өргөдөл, холбогдох баримт бичгийг ирүүлсэн өдрөөс 30 хоногийн дотор хянаж, бүртгэх эсэх асуудлыг шийдвэрлэнэ.

3.2. Үнэт цаасаа бүртгүүлэхээр ирүүлсэн өргөдөл, баримт бичигт заасан үнэт цаасны төрөл болон тоо хэмжээний хүрээнд тухайн үнэт цаасыг гадаад улсын үнэт цаасны зах зээлд байршуулах, арилжих үнэт цаасыг Хороонд бүртгэнэ.

3.3. Ирүүлсэн баримт бичиг, материал нь шаардлага хангаагүй, бүрдэл дутуу нөхцөлд өргөдөл гаргагчид буцаах ба дахин бүрдүүлэн ирүүлсэн өдрөөс эхлэн хянах өдрийг тооцно.

### **ДӨРӨВ. ХЯНАЛТ, ХАРИУЦЛАГА**

4.1. Монгол улсад бүртгэлтэй хуулийн этгээд нь гадаадын үнэт цаасны зах зээлд үнэт цаасаа байршуулсан, арилжаалсан тухай тайлангаа Хороонд ирүүлнэ.

4.2. Хороо энэхүү журмын биелэлтэд хяналт тавьж холбогдох хууль тогтоомж зөрчсөн этгээдэд Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 38.1-д заасан хариуцлага хүлээлгэнэ.

**ГАДААД УЛСЫН ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛД БАЙРШУУЛАХ,  
АРИЛЖИХ ҮНЭТ ЦААСАА БҮРТГҮҮЛЭХ ӨРГӨДӨЛ**

Огноо : .....

Хаана: Санхүүгийн зохицуулах хороо,

Засгийн газрын IV байр

Бага тойруу -6

Улаанбаатар -46

Монгол улс.

Хэнээс: .....

.....

.....

(өргөдөл гаргагчийн овог, нэр, хаяг, утас, факс, шуудангийн ба электрон шуудангийн хаяг)

.....

/хуулийн этгээдийн нэр/ /ХК, ХХК/

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн ..... заалт, Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны 6 дугаар сарын 28-ны өдрийн ..... тоот тогтоолоор баталсан “Монгол улсад бүртгэлтэй хуулийн этгээдээс гадаадын үнэт цаасны зах зээлд гаргах үнэт цаасыг бүртгэх журам”-ыг үндэслэн

.....

(ХК, ХХК-ийн нэр)

.....

(эрх бүхий байгууллагын нэр)

.....

(Үнэт цаасаа гаргах гэж буй гадаад улсын нэр)

.....

(Үнэт цаасаа байршуулах, арилжих хөрөнгийн биржийн нэр) дээр

..... байршуулан арилжих гэж байгаа тул бүртгэнэ үү.

(үнэт цаасны төрөл)

**ӨРГӨДӨЛ ГАРГАГЧ:**

/тамга тэмдэг/

.....

/хуулийн этгээдийн нэр/ /албан тушаал /

/..... /

/гарын үсэг/ /овог, нэр/

## **ӨРИЙН БИЧГИЙН ТАНИЛЦУУЛГА ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ**

1. Монгол улсад бүртгэлтэй хуулийн этгээдийн оноосон нэр:
2. Монголын хөрөнгийн бирж болон бусад орны хөрөнгийн биржүүд дээр өрийн бичиг өмнө нь гаргаж байсан бол биржийн нэр, листингийн төрөл зэрэг мэдээлэл

## **ӨРИЙН БИЧГИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ**

1. Үнэт цаас гаргагчийн өрийн бичгийг бүртгэх байгууллагын нэр, бүртгэлийн дугаар болон бүртгэсэн огноо
2. Өрийн бичиг гаргах валютын нэр, гаргах хэлбэр
3. Гаргах өрийн бичгийн тоо ширхэг
4. Өрийн бичгийн нэрлэсэн үнэ
5. Эргэлтэд байх болон байршуулах хугацаа, гадаад улсын үнэт цаасны зах зээлд байршуулах үнэ тогтоосон нөхцөл
6. Өрийн бичгийн төрөл /купонтой, хямдруулсан, баталгаатай болон баталгаагүй зэргийн аль нь болох/
7. Баталгаатай өрийн бичиг гаргаж буй нөхцөлд баталгааг дурдана. /Үнэт цаас гаргагчийн хөрөнгөөр барьцаа болгон хариуцлага хүлээх болон гуравдагч этгээд баталгаа гаргаж байгаагийн аль нь болох/
8. Үнэт цаас гаргагчийн болон түүний гаргаж буй үнэт цаасны рейтинг тогтоосон байгууллагын тодорхойлолтын албан ёсны хуулбар
9. Үнэт цаас гаргах мэдээлэлтэй хөрөнгө оруулагчид танилцаж болох хаяг, мэдээлийн эх үүсвэрийн нэр
10. Өрийн бичгийн хүү тооцох болон олгох тухай журам, өрийн бичиг эзэмшигчдэд олгох хүүгийн хэмжээ, хүү төлөх үечлэл
11. Өрийн бичиг эзэмшигчид нь хүү болон үндсэн төлбөрөө авах газрын хаяг байршил, үндсэн төлбөрийг олгох хугацаа
12. Үнэт цаас гаргагчийн санхүүгийн тайлантай өрийн бичиг эзэмшигч танилцах журам
13. Хөрөнгө оруулагчдад шаардлагатай бусад мэдээлэл / өгөөж олгох валют г.м./

Үнэт цаас гаргагчийн  
эрх бүхий этгээдийн овог, нэр

/гарын үсэг/

ТАМГА

**МОНГОЛ УЛСАД БҮРТГЭЛТЭЙ ХУУЛИЙН ЭТГЭЭД ГАДААДЫН  
ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛД ҮНЭТ ЦААСАА БАЙРШУУЛАХ, АРИЛЖИХ  
БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ**

Монгол улсын Санхүүгийн зохицуулах хорооноос Монгол улсад бүртгэлтэй

.....  
/Хаяг байршил/  
.....

-д  
/ Хуулийн этгээдийн оноосон нэр /

..... улсын үнэт цаасны зах зээлд

/Гадаад улсын нэр/  
.....

..... дээр

/Гадаад улсын бүртгэх эрх бүхий байгууллагын нэр, хаяг байршил/  
.....

.....  
/Гаргаж буй үнэт цаасны төрөл, тоо ширхэг, нэрлэсэн үнэ/ бүртгэв.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН